



ДУНДГОВЬ АЙМАГ  
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 11/41

Аргатай


Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
дуудлага худалдаа зохион байгуулах тухай


Монгол Улсын Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам, дуудлага худалдааг дахин явуулах 10.1 заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлэх газрын хэмжээ, зориулалт байршил, хугацаа, дуудлага худалдаа явуулах өдрийг хавсралтаар баталсугай.

Хоёр: Дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулж, дуудлага худалдааны зар мэдээг [www.mle.mn](http://www.mle.mn) газрын цахим биржид болон мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй зарлан явуулсугай.

Гурав: Дуудлага худалдаа явуулах хугацаа, тавигдах шаардлага нөхцлүүдийг тодорхойлон олон нийтэд зарлан мэдэгдэж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Газрын даамал (Т.Шуухааз)-д даалгасугай.





Баянжаргалант сумын засаг даргын  
2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр  
ТООТ Захирагч

ДУУДЛАГА ХУДАЛДАА ЯВУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ,  
ХЭМЖЭЭ ЗОРИУЛЛАГТ

№	Газрын Байршил	Газрын хэмжээ /м2/	Зориулалт	Дуудлага худалдаа явуулах хэлбэр	Дуудлага худалдаа явуулах анхны үнэ /төгрөг/	Дуудлага худалдаа явуулах өдөр
1	Аргатай 3-р баг Тунамалт ХХК-н ШТС-н баруун талд залгаа	10000	ШТС	Цахимаар	8,000,000	2023 оны 08 дугаар сарын 14-ны өдөр

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

--000--